



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/15

Улаанбаатар хот

“Талын салхи-2023” олон улсын мото  
наадам зохион байгуулах ажлын хэсэг  
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Газрын дүрмийн 4.1.5, 4.1.8, 4.1.10, 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсад Улаанбаатар хотыг сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгож, тэдний сонирхлыг татах зорилгоор “Талын салхи-2023” олон улсын мото наадмыг “Чингис” мотоциклын клубтай хамтран 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсугай.

2. “Талын салхи-2023” олон улсын мото наадмыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


3. Арга хэмжээг зохион байгуулах захирамжийн төсөл, ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, бэлтгэл ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (В.Батчимэг)-т даалгасугай.

ДАРГА *D. Batuy* Д.БАТЦҮХ



1150500087

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2023 оны 03 сарын 20 өдрийн  
А/15 дугаар тушаалын хавсралт



**“ТАЛЫН САЛХИ-2023” ОЛОН УЛСЫН МОТО НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:	В.Батчимэг	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
Гишүүд:	С.Туул	Маркетинг, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
	Т.Туул	Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
	Б.Цолмонгэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн
	Д.Сайханчимэг	Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан
	Б.Анхбаяр	“Чингис” мотоциклын клубын дэд ерөнхийлөгч /зөвшилцсөнөөр/
	Б.Ёндонжамц	“Чингис” мотоциклын клубын удирдах зөвлөлийн гишүүн /зөвшилцсөнөөр/
	О.Хашболд	“Чингис” мотоциклын клубын удирдах зөвлөлийн гишүүн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга:	Б.Үржинханд	Эвент хариуцсан мэргэжилтэн